



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 0197

Хэрлэн сум

Шатахуун зарцуулалтын нормыг
нэмэгдүүлж тооцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Онцгой комиссын 2017 оны 02 сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2016-2017 оны өвөл тус аймгийн ихэнх нутгаар удаа дараа цас орсны улмаас нийт нутгийн 70 хувь цагаан болон цагаанаар зудархуу ангилалд багтаж цасны дундаж зузаан 15-30 см хүрч хатууран, нягт 0,25-30 грм/ см күб, хөрний зузаан 10-15 см болон машин техник явахад хүндрэлтэй байдал үүсч автомашины шатах тослох материалын зарцуулалт хэвийн хэмжээнээс хэтэрч байгаа тул шатахуун зарцуулалтыг нэмэгдүүлэн тооцсугай.

2. Өмнөдэлгэр, Батширээт, Дадал, Норовлин, Баян-Овоо, Батноров, Хэрлэн сумдын нутаг дэвсгэрт 2017 оны 01 сарын 01-ний өдрөөс 04 сарын 01-ний өдрийг хүртэл шатахуун зарцуулалтын хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэн тооцохыг сумдын Засаг дарга, аж ахуйн нэгжийн дарга эрхлэгч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Хэрлэнчулуун/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА